12

МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60
Цахим шуудан: info@csc.gov.mn

2024.08.14 № 01/1749

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт, чадавхи, үйл ажиллагааны талаарх Таны асуулгын хариуг хүргүүлж байна.

Юуны өмнө төрийн албаны шалгалт, сонгон шалгаруулалтын талаар товч мэдээлэл танилцуулья.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах зорилгоор төрийн албаны мэргэшлийн шалгалт авдаг. Төрийн албаны шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Төрийн албаны зөвлөлөөс төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулж, төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар 12 удаа зохион байгуулаад байна. Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад давхардсан дүнгээр 75793 иргэн бүртгүүлснээс 59340 буюу 78.3 % нь шалгалтад оролцож, 19847 буюу 33.4% нь тэнцэн, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн.

Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэдийн хувь жил ирэх тутам өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2020 онд 31.1%, 2021 онд 31.7%, 2022 онд 33.4%, 2023 онд 41.1% нь нөөцөд бүртгэгджээ. Харин 2024 оны I, II улирлын ерөнхий шалгалтад оролцсон 7632 иргэний 26.9% нь тэнцсэн болно.

Төрийн албаны тухай хуулийн 33.8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор батлсан "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам"-ын 4.1 дэх хэсэгт зааснаар төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцөд байх хугацаа гурван жил байдаг бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 13709 иргэний нөөцөд байх хугацаа хүчинтэй хэвээр байна.

Төрийн албаны зөвлөлд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас 2020-2023 он, 2024 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн захиалгын дагуу улсын хэмжээнд төрийн захиргааны удирдах албан тушаалын 2831 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулсан. Энэхүү тусгай шалгалтанд 2518 иргэн өрсөлдөж, хамгийн өндөр авсан 1972 иргэнийг албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн бөгөөд тухайн албан тушаалд 69.7% нөхөгдсөн байна.

Улсын хэмжээнд 2020-2023 он, 2024 оны эхний хагас жилийн байдлаар төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 20762 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарласнаас 14910 иргэн өрсөлдөж, хамгийн өндөр авсан 9877 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, сул орон тооны 47.6%-ийг нөхсөн байна.

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 11849 орон тоо нөхөгдсөнөөс 3098 буюу 26.1% нь төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан

24004348

хаагчийн нөөцөөс, 751 буюу 6.3% нь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэний нөөцөөс, 5 буюу 0,04% нь төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад орж тэнцсэн иргэний нөөцөөс, 7747 буюу 65.4% нь төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэдийн нөөцөөс тус тус өрсөлдөж тухайн албан тушаалд нэр дэвшсэн байна.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 1340 сул орон тооны сонгон шалгаруулалтад 1579 иргэн өрсөлдөж, 800 иргэнийг нэр дэвшүүлж, сул орон тооны 59.7% нөхөгдсөн байна.

Үүнээс үзэхэд төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын хувьд 1 сул орон тоонд дунджаар 1 хүрэхгүй иргэн, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад дунджаар 1.2 иргэн өрсөлдөж байгаа нь төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа зэргээс шалтгаалан төрд ажиллахыг сонирхож буй иргэдийн тоо цөөн байгааг харуулж байна.

Давхардсан тоогоор төрийн захиргааны удирдах алба тушаалын 859, гүйцэтгэх албан тушаалын 10885 зарласан сул орон тоонд өрсөлдөхөөр материалаа ирүүлсэн албан хаагч, иргэд цөөн байгаатай шууд хамааралтай юм.

Нийт сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлсэн албан тушаалыг харьяаллаар нь ангилж үзвэл:

- Улсын Их Хурал Тамгын газар болон Улсын Их хурлаас удирдлага нь томилогддог байгууллага болон түүний харьяа байгууллагад 879;
- Засгийн газар болон яам, агентлагт 2655;
- Аймаг, нийслэл дэх төрийн захиргааны байгууллагад 8315;
- Төрийн үйлчилгээний байгууллагад 800 байна.

Ирүүлсэн захиалга, сонгон шалгаруулалт, сул орон тоо нөхөгдсөн байдлыг оноор нь авч үзвэл:

Он	Захиалгын тоо	Өрсөлдсөн иргэдийн тоо	Нэр дэвшүүлсэн тоо	Нөхөгдөөгүй албан тушаалын тоо
2020	2259	1421	1066	1193
2021	3495	3038	2130	1365
2022	6129	5354	3731	2398
2023	10803	7023	4582	6221
2024.6	2247	2171	1140	1107

Асуулга 1. Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд тавьсан хяналт шалгалт, хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, иргэн төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгахаар өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, түүний биелэлт, хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцөл:

Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт "... төрийн албаны төв байгууллага өөрөө, эсхүл иргэний гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ." гэж, 30.2 дахь хэсэгт "... хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна." гэж, 30.3 дахь хэсэгт "... үүрэг, даалгаврыг биелүүлээгүй бол төрийн албаны төв байгууллага хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгоно.", 66 дугаар зүйлийн 66.1.3 дахь заалтад "Зөвлөл иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах

хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөл өөрийн төлөвлөгөөт, иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хэлбэрээр төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Төрийн албаны зөвлөлөөс нийт 133 ажлын хэсэг байгуулан төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд:

- 2020 онд 6 байгууллагын 377 албан хаагч;
- 2021 онд 375 байгууллагын 5277 албан хаагч;
- 2022 онд 58 байгууллагын 1012 албан хаагч;
- 2023 онд 267 байгууллагын 4935 албан хаагч;
- 2024 оны 1-6 сард 482 байгууллагын 8483 албан хаагчийг хамруулан хяналт шалгалт хийсэн.

Нийт 1188 төрийн байгууллагын 20084 төрийн жинхэнэ албан хаагч хамрагдсан энэхүү шалгалтаар Төрийн албаны тухай хууль зөрчсөн, холбогдох журамд заасан тусгай шаардлагыг хангаагүй томилсон 2227 албан хаагч ажиллаж байсан томилгооны зөрчил илэрсэн. Хяналт шалгалтын явцад томилох эрх бүхий албан тушаалтан 376 албан хаагчид холбогдох зөрчлийг арилгасан.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хяналт шалгалтын тайланг хэлэлцэж, Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж 1851 иргэн, албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон зөрчилийг арилгуулах хугацаатай үүрэг, даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын хүрээнд 1475 албан хаагчид хамаарах зөрчлийг томилох эрх бүхий албан тушаалтан биелүүлсэн байна.

Томилгооны зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгаварыг хэрэгжүүлээгүй, Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлээгүй үндэслэлээр Зөвлөлийн хуралдаанаар асуудлыг дахин хэлэлцэж, 208 иргэн, албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй 40, шүүхийн маргаантай 5, нийт 45 албан хаагчид хамаарах зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг түдгэлзүүлсэн болно.

Төрийн албаны зөвлөлөөс 122 албан хаагчид холбогдох хугацаатай үүрэг, даалгавар өгсөн шийдвэрийг биелүүлсэн эсэх талаарх баримтыг томилох эрх бүхий албан тушаалтан ирүүлээгүй, 1 албан хаагчид холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх Зөвлөлөөс тогтоосон хугацаа болоогүй байна.

Иргэн, албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд хууль тогтоомж зөрчиж, хууль бусаар томилсныг Төрийн албаны зөвлөл тогтоосон тогтоолын хэрэгжилт бүрэн биелэгдэхгүй байгаа нь эрх бүхий этгээдийн хууль дээдлэх, хэрэгжүүлэх эрх зүйн мэдлэг дутмаг, хангалттай биш, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн ажлын байранд буруу томилгоо хийх, Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргаж, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэхгүй хугацаа алдах, тодорхой хэмжээнд улс төрийн нөлөөлөл их байдагтай холбоотой.

Төрийн албаны зөвлөл нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, гаргасан шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авах зорилгоор давтан хяналт шалгалт хийх, хууль бус томилгоо, чөлөөлөлт хийхээс урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлэх сургалтуудыг эрх бүхий албан тушаалтан, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд үе шаттай зохион байгуулах, эрх зүйн шинэчлэл хийх, Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг

эрхлэх газарт мэдээлэл санал өгөх, хууль бус томилгоотой холбоотой төрд учруулсан хохирлыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, эдийн засгийн хариуцлага тооцох зэрэг тодорхой арга хэмжээг авч ажиллан тодорхой зөрчил үр дүнд хүрч байна.

Асуулга 2. Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн шалгалт, илэрсэн зөрчлийг арилгахаар хүргүүлсэн хугацаатай шаардлага, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээний биелэлт:

Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт бус хяналт, шалгалтад:

- 2020 онд 3 байгууллагын 60 албан хаагч;
- 2021 онд 81 байгууллагын 351 албан хаагч;
- 2022 онд 20 байгууллагын 220 албан хаагч;
- 2023 онд 10 байгууллагын 201 албан хаагч;
- 2024 оны 1-6 сард 3 байгууллагын 188 албан хаагчийг хамруулан хяналт шалгалт хийсэн.

Нийт 117 байгууллагын 1020 албан хаагч хамрагдсан энэхүү хяналт шалгалтаар Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон 254 иргэн албан хаагч ажиллаж байсан томилгооны зөрчил илэрсэн. Хяналт шалгалтын явцад томилох эрх бүхий албан тушаалтан 27 албан хаагчид холбогдох зөрчлийг арилгасан.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар 2020-2023 он, 2024 оны эхний хагас жилийн байдлаар хяналт, шалгалтын тайланг хэлэлцэж, 227 албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон зөрчилийг арилгуулах хугацаатай үүрэг, даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж, хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлсэн албан тушаалтныг төрлөөр нь авч үзвэл 100 удирдах, 127 гүйцэтгэх албан тушаалтан байв. Үүнийг оноор нь авч үзвэл:

- 2020 онд 1 удирдах, 1 гүйцэтгэх албан тушаалтан;
- 2021 онд 71 удирдах, 79 гүйцэтгэх албан тушаалтан;
- 2022 онд 10 удирдах, 12 гүйцэтгэх албан тушаалтан;
- 2023 онд 4 удирдах, 8 гүйцэтгэх албан тушаалтан;
- 2024 онд 14 удирдах, 27 гүйцэтгэх албан тушаалтанд хамаарах зөрчил арилгуулах хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын хүрээнд 171 албан хаагчид хамаарах зөрчлийг томилох эрх бүхий албан тушаалтнууд биелүүлсэн байна.

Томилгооны зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгаварыг хэрэгжүүлээгүй, Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлээгүй үндэслэлээр Зөвлөлийн хуралдаанаар асуудлыг дахин хэлэлцэж, 37 иргэн, албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй 3, шүүхийн маргаантай 2, нийт 5 албан хаагчид хамаарах зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг Зөвлөлөөс түдгэлзүүлсэн болно.

Төрийн албаны зөвлөлөөс 14 албан хаагчид холбогдох хугацаатай үүрэг, даалгавар өгсөн шийдвэрийг биелүүлсэн эсэх талаарх баримтыг томилох эрх бүхий албан тушаалтан ирүүлээгүй байна.

Асуулга 3. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ажлын хэрэгжилт:


Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн албан хаагчийн тоо бүртгэлийг хөтөлж, жил бүрийн 12 дугаар

сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тайлан гаргадаг. Тоо бүртгэлийн мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлдэг. Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийн дэлгэрэнгүй тайланг Улсын Их Хуралд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хүргүүлдэг.

Хүснэгт №3.1. Төрийн албан хаагчийн тоо 2020, 2021, 2022, 2023 он болон 2024 оны эхний хагас жилийн байдлаар

№	Ангилал	2020	2021	2022	2023	2024.06
1	Төрийн тусгай	45,453	45,899	47,158	47,657	47,689
2	Төрийн үйлчилгээ	135,386	137,665	152,265	153,302	155,827
3	Төрийн захиргаа	20,553	21,135	22,023	21,639	22,002
4	Төрийн улс төрийн	3,619	4,165	3,759	3,898	4,103
Нийт		205,011	208,864	225,205	226,496	229,621

Төрийн албан хаагчийн тооны динамик өөрчлөлт:



Төрийн албан хаагчийн тоог Монгол Улсын хүн ам болон ажиллах хүчний тоонд харьцуулбал,

Хүснэгт№3.1 Төрийн албан хаагчийн Монгол Улсын хүн ам болон ажиллах хүчинд эзлэх хувь

№	Он	Төрийн албан хаагчийн тоо	Хүн амын тоо	Ажиллах хүчний тоо	Хүн амын тоонд эзлэх хувь	Ажиллах хүчинд эзлэх хувь
1	2020	205,011	3,253,283	1,250,608	6.30%	16.39%
2	2021	208,864	3,312,275	1,225,373	6.31%	17.04%
3	2022	225,205	3,368,632	1,265,211	6.69%	17.80%
4	2023	226,496	3,396,788	1,285,103	6.67%	17.62%

Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн цахим систем"-ээр хөтөлдөг. Энэхүү системийг 2020 оноос эхлэн нэвтрүүлж, тасралтгүй хөгжүүлэлт хийн ажиллаж байна.

Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн систем нь дараах 13 модультай. Үүнд:

Суурь платформ;

Үндсэн хүний нөөц;

Ажиллах хүчний удирдлага;

Сургалтын удирдлага;

Статистик тайлан мэдээ;

Ажилтны цалин хөлс, тэтгэмж;

Сонгон шалгаруулалт, томилгоо;

Ажилтны карьер, хөгжил;

Гүйцэтгэлийн удирдлага;

Ажиллах үеийн дэмжлэг;

Хүний нөөцийн шинжилгээ;

Хүний нөөцийг оновчтой болгох;

Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт.

Төрийн албаны "ХНУМТ" цахим системийг бүрэн хөгжүүлж, нэвтрүүлснээр төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрэн цахимд шилжиж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тогтолцоо бий болж, төрийн албатай холбоотой бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай их өгөгдлийн төрийн албаны дэд хэсэг бий болгох зорилготой.

ХНУМТ" цахим систем нь Боловсролын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Цагдаагийн ерөнхий газар, Монгол банк, Татварын ерөнхий газар болон Удирдлагын академийн мэдээллийн сангаас албан хаагчийн анхдагч мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан авч Сангийн яамны Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, Архивын ерөнхий газрын Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн систем, Боловсролын яамны Боловсролын систем, Сонгуулийн ерөнхий хорооны хяналтын систем, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны бүртгэлийн систем болон Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих системд мэдээлэл нийлүүлж байна.

Төрийн албаны "ХНУМТ" цахим системийг Сангийн яамны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-тэй холбож мэдээлэл солилцоог сайжруулснаар систем ашиглаж байгаа байгууллагуудын хэмжээнд төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэл, үндсэн цалин тогтоох, нэмэгдэл хөлсийг олгож байгаа байдалд бүрэн хяналт тавьж байна.

Төрийн албаны "ХНУМТ" цахим системд 2024 оны 7 дугаар сарын 22-ны байдлаар Сангийн яамны төрийн албаны цалингийн системээр цалингаа тооцон олгодог төрийн, төрийн болон орон нутгийн өмчит 4469 байгууллага, хөдөлмөр эрхэлж байгаа 203456 албан хаагч, иргэний анкет, ажил эрхлэлт, мэргэшсэн талаарх бүртгэл байна. Цалингийн сүлжээний 102, сар бүр тогтмол олгодог нэмэгдлийн 115 төрлийн 400 бүртгэлийг ашиглан тухайн албан хаагчийн цалин хөлсийг тогтоосон талаарх мэдээлэл агуулагдаж өдөр тутам баяжилт хийгдэж байна.

Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр нөөцөд бүртгэгдэхээр чөлөөлөгдсөн албан хаагчийн мэдээллийг системд бүртгэн, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэн бусад байгууллагын хүний нөөцөд ашиглах нөхцөлийг бүрдүүлснээр тусгай шаардлага хангасан иргэнийг нөөцөөс авч ажиллуулах боломжтой болсон.

ХНУМТ цахим системийг Сангийн яамны Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих систем, Архивын ерөнхий газрын Албан

хэрэг хөтлөлтийн систем, Боловсролын салбарын мэдээллийн систем, Төрийн албаны шалгалтын цахим системүүдтэй мэдээлэл солилцож, мэдээлэл бүрдүүлэгч анхдагч эх үүсвэрээс санг бүрдүүлэн мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж байна.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Асуулга 4. Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгох, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлсэн болон түүний биелэлт, биелэхгүй байгаа шалтгаан нөхцөл:

Төрийн албаны тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсэгт "Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ." гэж заасан.

Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдолоор Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар 2020 онд 22, 2021 онд 90, 2022 онд 63, 2023 онд 46, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 21, нийт 242 маргаан үүсгэж, маргаан хянан шалгах комисс байгуулан ажилласан.

Эрх бүхий албан тушаалтан, төрийн албан хаагчдын хоорондүүссэн маргаан бүхий захиргааны 242 актыг агуулгаар нь авч үзвэл:

- 92 шийдвэр буюу 38% нь сахилгын шийтгэл ногдуулсан;
- 78 шийдвэр буюу 32.2% нь албан тушаалаас нь түр чөлөөлсөн, чөлөөлсөн;
- 20 шийдвэр буюу 8.3% нь төрийн албанаас халсан;
- 24 шийдвэр буюу 9.9% нь төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулсан;
- 8 шийдвэр буюу 3.3% нь албан тушаалд сонгон шалгаруулж томилохтой холбоотой;
- 2 шийдвэр буюу 0.8% нь өөр ажил албан тушаалд шилжүүлэн ажиллуулсан;
- 18 шийдвэр буюу 7.4% нь албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой асуудлаар гаргасан байна.

Маргаан үүсгэн хянан шалгах явцад зөрчил арилсан, шүүхэд хандсан, тухайн албан тушаалд гомдол гаргагч хууль бусаар томилсныг тогтоосон, гомдлоосоо татгалзсан, харьяаллын бус маргаан зэргээр 94 гомдолд хууль тогтоомжийн хүрээнд гомдолд гаргагчид зохих хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.

Төрийн албаны зөвлөл маргаан хянан шалгах комиссын 147 дүгнэлтийг хэлэлцэн эрх бүхий этгээдийн 93 шийдвэрийг хүчингүй болгох, 54 шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэйд тооцон хэвээр үлдээн шийдвэрлэж, Зөвлөлийн нийт 147 тогтоол гарсан.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэгдээгүй, ажиллагаа хийгдэж байгаа 1 маргаан байгаа болно.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар төрийн албан хаагч болон уг албанд нэр дэвшигчийн хооронд үүссэн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгосон нийт 93 тогтоолын хэрэгжилтийг танилцуулбал:

- 86 буюу 92.4%-ийг эрх бүхий албан тушаалтан биелүүлсэн;
- 2 буюу 2.1 %-ийг эс зөвшөөрч, шүүхэд нэхэмжлэл гаргасан;

- 5 буюу 5.3 %-ийг биелүүлээгүй тул буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг томилсон эрх бүхий этгээдэд хүргүүлсэн.

Буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдэл нь Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлээгүй үндэслэлээр 5, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй үндэслэлээр 3 мэдэгдэл хүргүүлсэн байна. Үүнийг оноор нь авч үзвэл:

- 2020 онд 2,
- 2021 онд 4,
- 2022 онд 1,
- 2024 онд 1 мэдэгдэл тус тус хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн хүргүүлсэн мэдэгдлийн дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга, Гаалийн ерөнхий газрын дарга зэрэг албан тушаалныг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн.

Харин Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг дарга, Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг дарга, Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга зэрэг албан тушаалтныг чөлөөлөөгүй байна.

Асуулга 5. Төрийн албаны хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоосон байдал, энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан:

Асуулгын 1-4-т заасан мэдээллээс гадна Төрийн албаны зөвлөл нь төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар Төрийн албаны тухай хуульд заасан зарим чиг үүргийг хэрэгжүүлэн, шүүхэд төлөөлөн оролцож, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу төрд учруулсан гэм хорын хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэгчээр, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн иргэн, албан хаагчийн гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцон ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд иргэний 206 хэрэгт нэхэмжлэгчээр, давхардсан тоогоор захиргааны 94 хэрэгт хариуцагчаар, эрүүгийн 1 хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тус тус оролцсон. Эрүү, иргэн, захиргааны нийт 303 хэрэгт шүүхэд төлөөлөл хэрэгжүүлэхдээ давхардсан тоогоор анхан шатны шүүх хуралдаанд 567, давж заалдах шатны шүүх хуралдаанд 205, хяналтын шатны шүүх хуралдаанд 75 удаа оролцсон.

Төрийн албаны зөвлөлийн нэхэмжлэлтэй төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага бүхий иргэний хэргийн шүүх 53 нэхэмжлэлийг хангаж, 5 нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 148 иргэний хэрэг байна.

Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрч иргэн, албан хаагчийн гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүх 83 нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 5 нэхэмжлэлийг хангаж, 6 захиргааны хэрэг ажиллагаанд байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой захиргааны хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч, захиргааны шийдвэр гаргадаг төрийн байгууллага, албан тушаалтан шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхгүй талаар захиргааны хэргийн шат шатны шүүхийн жишиг шийдвэрүүд гарч, хууль хэрэглээний шинэ практик тогтоосон нь хуульд заасан Зөвлөлийн шийдвэрийг холбогдох этгээд заавал биелүүлдэг байх зарчим хэрэгжих нөхцөл бүрдэж, Зөвлөлийн шийдвэрийн үр нөлөө, ач холбогдол нэмэгдсэн нь шинэтгэл дэх томоохон ахиц дэвшил юм.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Төрийн албаны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны тев байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж, 50.2 дахь хэсэгт "Төрийн албаны тев байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана" гэж заасан.

Энэ нь иргэнийг төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалд хууль бусаар томилсныг Төрийн албаны зөвлөл болон шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд орсон дээрх өөрчлөлттэй холбоотой төрийн албаны хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын эрх зүйн зохицуулалт, хуулийн үйлчлэх хүрээ илүү өргөжин томилох эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлагыг тодорхойлон заасан төдийгүй төрийн албаны шинэтгэл дэх эдийн засгийн хариуцлага тооцох зохицуулалтыг илүү тодорхой болгож хуульчилсан явдал юм.

Нөгөөтээгүүр төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд тавих хяналт нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага хохирлоо барагдуулах зохицуулалттай уялдуулан иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг Төрийн албаны зөвлөл, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт "Төрийн албаны тев байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлнө" гэж заасны дагуу хууль бус шийдвэр гаргасан 288 албан тушаалтанд холбогдох 4.049.949.879 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх бүртгэл хөтөлж, хэрэгжүүлэх шаардлагыг эрх бүхий этгээдэд хүргүүлсэн. Эдгээрийг оноор нь ангилж үзвэл:

- 2020 онд 1 албан тушаалтанд 6.600.000 төгрөг
- 2021 онд 20 албан тушаалтанд 221.600.000 төгрөг
- 2022 онд 27 албан тушаалтанд 303.000.000 төгрөг
- 2023 онд 135 албан тушаалтанд 1.817.123.820 төгрөг
- 2024 оны 1-6 сард 105 албан тушаалтанд 1.701.626.059 төгрөг.

Хохирол нөхөн төлөх албан тушаалтныг харьяаллаар давхардсан тоогоор авч үзвэл:

- Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын 11 албан тушаалтан
- Засгийн газар, түүний харьяа байгууллагын 135 албан тушаалтан
- Аймаг 283, нийслэл 61
- Бусад 2

Төрийн албаны зөвлөлөөс хүргүүлсэн шаардлагыг биелүүлээгүй 206 иргэн, албан тушаалтанд холбогдох 3.599.759.661 төгрөгийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг харьяаллын дагуу дүүрэг болон орон нутгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Төрийн албаны зөвлөлөөс хүргүүлсэн шаардлагын биелэлтийг оноор нь авч үзвэл:

- 2020 онд 1 албан тушаалтнаас 4.400.000 төгрөг төлсөн
- 2021 онд 1 албан тушаалтнаас 2.900.000 төгрөг төлсөн
- 2022 онд 1 албан тушаалтнаас 10.997.900 төгрөг төлсөн
- 2023 онд 13 албан тушаалтан 167.010.045 төгрөг төлсөн
- 2024 оны 1-6 сард 22 албан тушаалтан 95.773.437 төгрөг төлж төрийг хохиролгүй болгосон байна.

Төрийн албаны зөвлөлийн шаардлага болон шүүхийн шийдвэрийн дагуу 705.606.476 төгрөгийг буруутай албан тушаалтан нөхөн төлж, төрийн сангийн 100900021501 тоот дансанд төвлөрүүлж байна.

Шүүхийн шийдвэрээр буруутай нь тогтоогдсон төрд хохирол учруулсан 14 албан тушаалтанд холбогдох 156.052.311 төгрөгийг албадан гүйцэтгүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан.

Төрийн албаны зөвлөл нь томилох эрх бүхий этгээдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах зөвлөмж зөвлөгөө өгөх, сургалт, мэдээлэл зохион байгуулснаар иргэнийг төрийн албанд хууль бусаар томилох, чөлөөлөх, түр чөлөөлөх, халахтай холбоотой хууль бус шийдвэр гаргаснаас үүдэх сөрөг үр дагаврыг ойлгон ухамсарлаж, төрд учирсан хохирлыг Төрийн албаны зөвлөлийн шаардлагын дагуу сайн дураар нөхөн төлөх явц сайжирч, энэ чиглэлийн зөрчил багасаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, 66 дугаар зүйлийн 66.1.3 дахь заалтад тус тус заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг оноор, байгууллагаар нь гарган хавсаргав.

Хавсралт:

1.Төрийн албаны шалгалт, сонгон шалгаруулалтын мэдээлэл;

2.Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын мэдээлэл

3.Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэл;

4.Томилох эрх бүхий этгээд болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэсэн, түүнчлэн төрийн албаны төв байгууллага, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдэл хүргүүлсэн талаарх мэдээлэл;

5.Төрд учруулсан хохирол болон нөхөн төлөлтийн мэдээлэл;

6.Шүүхэд төлөөлж буй хэрэг болон шүүх хуралдааны тоон мэдээлэл.

ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН

Төрийн албаны зөвлөлийн
2024 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн
01/179 дугаар албан бичгийн хавсралт

Хүснэгт 1. Төрийн албаны ерөнхий шалгалтын тоон мэдээлэл

Агуулга		2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он		2024 он /нийт/	Нийт /давхардсан дүнгээр/
						I улирал	II улирал		
Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдийн тоо		16218	22299	13559	16085	4221	3411	7632	**75793**
Үүнээс	Төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн хүний тоо	12286	17292	11180	12683	3298	2601	5899	**59340**
	Шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн хүмүүсийн тоо, хувь	**3823** /31.1%/	**5484** /31.7%/	**3739** /33.4%/	**5212** /41.1%/	462 /14.0%/	1127 /43.3%/	**1589** /27.0%/	**19847** /33.4%/
	Ерөнхий мэдлэгийн шалгалтад тэнцсэн хүний тоо	5017	7343	4991	6601	1131	1412	2543	**26495**
	Монгол хэл бичгийн чадварын шалгалтад тэнцсэн хүний тоо	4070	5858	3944	5467	987	1232	2219	**21558**
	Дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад тэнцсэн хүний тоо	3823	5484	3739	5212	462	1127	1589	**19847**

Хүснэгт 2. Төрийн албаны тусгай шалгалтын мэдээлэл

№	Он	Төрийн захиргааны удирдах албан тушаалын			Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын			Нийт дүн	
		зарлагдсан сул орон тоо	шалгалтад оролцсон иргэний тоо	нэр дэвшсэн	зарлагдсан сул орон тоо	шалгалтад оролцсон иргэний тоо	нэр дэвшсэн	зарлагдсан сул орон тоо	нэр дэвшсэн
1	2020 он	450	420	350	1581	686	576	2031	928
3	2021 он	441	398	343	2802	2403	1651	3243	1994
4	2022 он	729	656	555	5042	4347	2950	5771	3505
5	2023 он	969	808	570	9403	5583	3746	10372	4316
6	2024 оны II улирлын байдлаар	242	236	154	1934	1889	952	2176	1106
Нийт		**2831**	**2518**	**1972**	**20762**	**14910**	**9877**	**23593**	**11849**

Хүснэгт 3. 2020 оны хяналт, шалгалтын тоон мэдээлэл

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн тоо	Хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлж зөрчлийг арилгасан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлт түр түдгэлзсэн		Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн тогтоолыг биелүүлээгүй албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцэж хүчингүй болгосон албан хаагчийн тоо
						Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд хандсан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолд холбогдох жирэмсний амрал болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн тоо		
	Нийт 6	**377**	**32**	**32**	**32**	-	-	-	-
1	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	248	24	24	24	-	-	-	-
2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	69	6	6	6	-	-	-	-
3	Увс аймгийн Засаг даргын Тамгын газар	13	1	1	1	-	-	-	-
4	Өвөрхангай аймгийн Хархорин сумын ИТХ	1	1	1	1	-	-	-	-
5	Цаг уур, орчны шинжилгээний газар	46	-	-	-	-	-	-	-

Хүснэгт 4. 2021 оны хяналт, шалгалтын тоон мэдээлэл

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн тоо	Хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлж зөрчлийг арилгасан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлт түр түдгэлзсэн		Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн тогтоолыг биелүүлээгүй албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцэж хүчингүй болгосон албан хаагчийн тоо
						Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд хандсан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолд холбогдох жирэмсний амрал болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн тоо		
I	II	II	IV	V	VI	VII	VIII	IX	X
Нийт 375		**5277**	**1112**	**1112**	**899**	**3**	**17**	**-**	**193**
Нийт яам		**154**	**34**	**34**	**19**	**-**	**-**	**-**	**15**
1	Эрчим хүчний яам	2	2	2	1	-	-	-	1
2	Гадаад харилцааны яам	1	1	1	1	-	-	-	-
3	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	1	1	1	1	-	-	-	-
4	Соёлын яам	1	1	1		-	-	-	1

5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	1	1	1	-	-	-	-
6	Байгаль орчин аялал жуулчлалын яам	2	2	2	1	-	-	-	1
7	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	109	14	14	9	-	-	-	5
8	Эрүүл мэндийн яам	35	10	10	3	-	-	-	7
9	Эдийн засаг хөгжлийн яам	2	2	2	2	-	-	-	-
Нийт агентлаг		**293**	**61**	**61**	**47**			**-**	**14**
10	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	57	14	14	8	-	-	-	6
11	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	30	3	3	3	-	-	-	-
12	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	35	8	8	6	-	-	-	2
13	Төрийн худалдан авах ажиллагааны газар	13	4	4	3	-	-	-	1

14	Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар	13	4	4	4	-	-	-	-
15	Нийгмийн даатгалын ерөнхий газар	80	5	5	5	-	-	-	-
16	Усны газар	1	1	1	1	-	-	-	-
17	Соёл урлагийн газар	4	3	3	3	-	-	-	-
18	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	21	2	2	2	-	-	-	-
19	Гаалийн ерөнхий газар	12	8	8	4	-	-	-	4
20	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	7	2	2	2	-	-	-	-
21	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	14	1	1	1	-	-	-	-
22	Жижиг дунд үйлдвэрийн газар	5	5	5	4	-	-	-	1
23	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	1	1	1	1	-	-	-	-
Нийслэл		**70**	**26**	**26**	**17**	**-**	**-**	**-**	**9**
24	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	26	3	3	1	-	-	-	2

25	Нийслэлийн Баянгол дүүргийн ИТХ	6	6	6	3	-	-	-	3
26	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	3	3	3	1	-	-	-	2
27	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар	2	2	2	2	-	-	-	-
28	Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар	24	3	3	3	-	-	-	-
29	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газар	1	1	1	-	-	-	-	1
30	Нийслэлийн орон сууцны дэд бүтцийн газар	1	1	1	1	-	-	-	-
31	Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар	2	2	2	2	-	-	-	-

32	Нийслэлийн Дотоод аудитын газар	3	3	3	3	-	-	-	-
33	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	1	1	1	-	-	-	-	1
34	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	1	1	1	1	-	-	-	-
Орон нутаг		**4744**	**975**	**975**	**804**	**3**	**17**	**-**	**151**
35	Архангай аймаг	399	97	97	70	-	1	-	26
36	Булган аймаг	394	76	76	66	-	3	-	7
37	Говь-Алтай аймаг	423	125	125	106	-	2	-	17
38	Дорнод аймаг	483	71	71	60	-	-	-	11
39	Дундговь аймаг	342	78	78	67	-	2	-	9
40	Завхан аймаг	505	104	104	87	-	1	-	16
41	Өмнөговь аймаг	449	86	86	76	-	1	-	9
42	Сүхбаатар аймаг	363	74	74	57	-	2	-	15
43	Увс аймаг	431	98	98	76	-	-	-	22
44	Ховд аймаг	415	52	52	47	-	1	-	4
45	Хөвсгөл аймаг	524	98	98	84	2	4	-	8
46	Төв аймаг	3	3	3	-	-	-	-	3
47	Баянхонгор аймаг	2	2	2	1	-	-	-	1
48	Баян-өлгий аймаг	2	2	2	1	1	-	-	-
49	Өвөрхангай аймаг	1	1	1	1	-	-	-	-
50	Дархан-Уул аймаг	3	3	3	1	-	-	-	2

51	Дорноговь аймаг	5	5	5	4	-	-	-	1
Бусад байгууллага		**16**	**16**	**16**	**12**	-	-	-	-
52	Замын-Үүд чөлөөт бүсийн Ажлын алба	13	13	13	10	-	-	-	3
53	Баянгол, Хан-Уул Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	1	1	1	1	-	-	-	-
54	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар	1	1	1	1	-	-	-	-
55	Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газар	1	1	1	-	-	-	-	1

Хүснэгт 5. 2022 оны хяналт, шалгалтын тоон мэдээлэл

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн тоо	Хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлж зөрчлийг арилгасан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлт түр түдгэлзсэн		Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн тогтоолыг биелүүлээгүй албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцэж хүчингүй болгосон албан хаагчийн тоо
						Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд хандсан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолд холбогдох жирэмсний амрал болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн тоо		
I	II	II	IV	V	VI	VII	VIII	IX	X
Нийт 58		**1012**	**193**	**175**	**164**	**1**	**6**	**-**	**4**
Нийт 5 яам		**236**	**66**	**53**	**50**	**-**	**-**	**-**	**1**
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	86	30	21	21	-	-	-	-
2	Эрүүл мэндийн яам	81	22	18	18	-	-	-	-
3	Соёлын яам	66	12	12	10	-	1	-	1
4	Барилга, хот байгуулалтын яам	1	1	1	1	-	-	-	-
5	Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын яам	2	1	1	-	1	-	-	-
Нийт 12 агентлаг		**305**	**60**	**55**	**53**	-	**2**	**-**	-
6	Усны газар	27	14	14	14	-	-	-	-
7	Цаг уур, орчны шинжилгээний газар	25	7	7	7	-	-	-	-

8	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	135	13	13	12	-	1	-	-
9	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	83	20	15	14	-	1	-	-
10	Соёл, урлагийн газар	15	2	2	2	-	-	-	-
11	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	5	1	1	1	-	-	-	-
12	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар	1	-	-	-	-	-	-	-
13	Иргэний нисэхийн ерөнхий газар	1	-	-	-	-	-	-	-
14	Нийслэлийн Дотоод аудитын газар	6	-	-	-	-	-	-	-
15	Нийслэлийн Соёл, урлагийн газар	1	1	1	1	-	-	-	-
16	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар	5	2	2	2	-	-	-	-
17	Нийслэлийн БЗД-ийн Татварын хэлтэс	1	-	-	-	-	-	-	-
Нийт 8 аймгийн 11 байгууллага		**11**	**6**	**6**	**6**	-	-	-	-
18	Сүхбаатар аймаг	2	1	1	1	-	-	-	-

19	Архангай аймаг	2	2	2	2	-	-	-	-
20	Баянхонгор аймаг	1	1	1	1	-	-	-	-
21	Баян-Өлгий аймаг	1	-	-	-	-	-	-	-
22	Увс аймаг	1	-	-	-	-	-	-	1
23	Завхан аймаг	2	1	1	1	-	-	-	-
24	Хөвсгөл аймаг	1	1	1	1	-	-	-	-
25	Дорнод аймаг	1	-	-	-	-	-	-	-
Бусад 30 байгууллага		**460**	**61**	**61**	**55**	-	-	-	3
26	Багахангай дүүргийн 12 байгууллага	66	8	8	8	-	-	-	-
27	Багануур дүүргийн 13 байгууллага	137	19	19	13	-	3	-	3
28	Туул голын сав газрын захиргаа	16	4	4	4	-	-	-	-
29	Хан-Хэнтий тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	55	20	20	20	-	-	-	-
30	Шүүхийн сахилгын хороо	1	1	1	1	-	-	-	-
31	Санхүүгийн зохицуулах хороо	184	8	8	8	-	-	-	-

32	Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	1	1	1	1	-	-	-	-

Хүснэгт 6. 2023 оны хяналт, шалгалтын тоон мэдээлэл

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн тоо	Хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлж зөрчлийг арилгасан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлт түр түдгэлзсэн		Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн тогтоолыг биелүүлээгүй албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцэж хүчингүй болгосон албан хаагчийн тоо
						Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд хандсан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолд холбогдох жирэмсний амрал болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн тоо		
I	II	II	IV	V	VI	VII	VIII	IX	X
Нийт 267		**4935**	**476**	**291**	**257**	**1**	**13**	**9**	**11**
УИХ-аас удирдлага томилогддог байгууллага /нийт 2 байгууллага/		**25**	**13**	**13**	**13**	**-**	**-**	**-**	**-**
1	Сонгуулийн ерөнхий хороо	15	3	3	3	-	-	-	-
2	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн төв	10	10	10	10	-	-	-	-
Яам /нийт 3 байгууллага/		**191**	**23**	**10**	**10**	**-**	**-**	**-**	**-**
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	70	16	4	4	-	-	-	-

2	Зам, тээврийн хөгжлийн яам	120	6	5	5	-	-	-	-
3	Эдийн засаг хөгжлийн яам	1	1	1	1	-	-	-	-
Агентлаг /нийт 1 байгууллага/		**1**	**1**	**1**	**1**	-	-	-	-
1	Архивын ерөнхий газар	1	1	1	1	-	-	-	-
Дүүрэг /нийт 22 байгууллага/		**627**	**111**	**71**	**59**		**3**	**9**	-
1	Чингэлтэй дүүрэг /нийт 5 байгууллага/	143	35	21	20	-	1	-	-
2	Сүхбаатар дүүрэг /нийт 5 байгууллага/	125	1	1	1	-	-	-	-
3	Хан-Уул дүүрэг /Нийт 6 байгууллага/	171	21	6	6	-	-	-	-
4	Баянзүрх дүүрэг /Нийт 5 байгууллага/	187	54	43	32	-	2	9	-
5	Налайх дүүрэг /Нийт 1 байгууллага/	1	-	-	-	-	-	-	-
Нийт 15 аймаг /нийт 239 байгууллага/		**4091**	**328**	**196**	**174**	1	**10**	-	**11**
1	Архангай /нийт 2 байгууллага/	2	1	1	1	-	-	-	-
2	Баян-Өлгий /нийт 24 байгууллага/	460	15	14	13	1	-	-	-

3	Баянхонгор /нийт 24 байгууллага/	495	59	43	41	-	2	-	-
4	Булган /нийт 1 байгууллага/	4	-	-	-	-	-	-	-
5	Говьсүмбэр /нийт 26 байгууллага/	183	42	32	28	-	-	-	4
6	Дархан-Уул /нийт 18 байгууллага/	303	20	5	5	-	-	-	-
7	Дорнод /нийт 1 байгууллага/	1	-	-	-	-	-	-	-
8	Дорноговь /нийт 25 байгууллага/	316	60	47	35	-	6	-	6
9	Орхон /нийт 17 байгууллага/	299	18	10	10	-	-	-	-
10	Өмнөговь /нийт 1 байгууллага/	1	-	-	-	-	-	-	-
11	Өвөрхангай /нийт 22 байгууллага/	485	6	4	3	-	-	-	1
12	Сэлэнгэ /нийт 17 байгууллага/	325	43	6	5		1	-	-
13	Төв /нийт 20 байгууллага/	419	16	7	7	-	-	-	-
14	Ховд /нийт 21 байгууллага/	442	14	10	10	-	-	-	-
15	Хэнтий /нийт 20 байгууллага/	356	34	17	16	-	1	-	-

Хүснэгт 7. 2024 оны эхний хагас жилийн хяналт, шалгалтын тоон мэдээлэл

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн тоо	Хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг биелүүлж зөрчлийг арилгасан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлт түр түдгэлзсэн		Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн тогтоолыг биелүүлээгүй албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн тогтоолыг биелүүлэх хугацаа болоогүй
						Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд хандсан албан хаагчийн тоо	Төрийн албаны зөвлөлийн тогтоолд холбогдох жирэмсний амрал болон хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн тоо		
I	II	II	IV	V	VI	VII	VIII	IX	X
Нийт 482		**8483**	**414**	**241**	**123**	**-**	**4**	**113**	**1**
Яам /нийт 1 байгууллага/		**74**	**22**	**18**	**4**	**-**	**-**	**14**	**-**
1	Барилга, хот байгуулалтын яам	74	22	18	4	-	-	14	-
Нийслэлийн агентлаг /нийт 2 байгууллага/		**114**	**33**	**23**	**21**	**-**	**2**	**-**	**-**
1	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	77	14	12	12	-	-	-	-
2	Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	37	19	11	9	-	2	-	-
Дүүрэг /нийт 6 байгууллага/		**189**	**20**	**8**	**-**	**-**	**-**	**-**	
1	Сонгинохайрхан дүүрэг	189	20	8	8	-	-	-	-

	/нийт 6 байгууллага/								
Нийт 21 аймаг /нийт 473 байгууллага/		**8106**	**339**	**192**	**90**	**-**	**2**	**99**	**1**
1	Архангай /нийт 21 байгууллага/	406	31	24	12		-	12	-
2	Баянхонгор /нийт 24 байгууллага/	413	5	2	1	-	-	1	-
3	Баян-Өлгий /нийт 25 байгууллага/	429	3	2	2	-	-	-	-
4	Булган /нийт 24 байгууллага/	386	17	10	-	-	-	10	-
5	Говь-Алтай /нийт 22 байгууллага/	400	59	48	24	-	1	23	-
6	Говьсүмбэр /нийт 28 байгууллага/	184	10	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул /нийт 24 байгууллага/	393	6	4	-	-	-	4	-
8	Дорнод /нийт 21 байгууллага/	396	18	11	-	-	-	11	-
9	Дорноговь /нийт 21 байгууллага/	281	7	1	-	-	-	1	-
10	Дундговь /нийт 21 байгууллага/	290	18	9	4	-	-	5	-
11	Завхан /нийт 21 байгууллага/	444	34	23	16	-	1	6	-
12	Орхон /нийт 25 байгууллага/	413	1	-	-	-	-	-	-
13	Өвөрхангай /нийт 23 байгууллага/	429	-	-	-	-	-	-	-
14	Өмнөговь	409	10	-	-	-	-	-	-

	/нийт 21 байгууллага/								
15	Сүхбаатар /нийт 21 байгууллага/	329	19	3	2	-	-	1	-
16	Сэлэнгэ /нийт 21 байгууллага/	397	4	4	-	-	-	4	-
17	Төв /нийт 20 байгууллага/	393	17	1	-	-	-	-	1
18	Увс /нийт 21 байгууллага/	407	10	7	5	-	-	2	-
19	Ховд /нийт 24 байгууллага/	421	24	14	10	-	-	4	-
20	Хөвсгөл /нийт 24 байгууллага/	524	32	25	14	-	-	11	-
21	Хэнтий /нийт 21 байгууллага/	366	14	4	-	-	-	4	-

Хүснэгт 8.Төрийн албан хаагчийн тоон мэдээлэл

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024.эхний хагас жил
Монгол Улсын хүн амын тоо	**3,253,283**	**3,312,275**	**3,368,632**	**3,396,788**	
Төрийн албан хаагчийн тоо	**205,011**	**208,864**	**225,205**	**226,496**	**229,621**
Хүн амд эзлэх хувь	6.3	6.3	6.68	6.67	
удирдах	11920	16232	16847	16602	17026
гүйцэтгэх	116089	143243	149450	178880	179611
туслах	35181	49389	58908	31014	32984
Төрийн улс төр	**3,619**	**4,165**	**3,759**	**3,898**	**4,103**
удирдах	3008	3245	3236	3332	3503
гүйцэтгэх	520	525	271	315	354
туслах	91	395	252	251	246
Төрийн захиргаа	**20,553**	**21,135**	**22,023**	**21,639**	**22,002**
удирдах	2822	2029	3076	2950	2973
гүйцэтгэх	16827	17780	18515	18689	19029
туслах	904	1326	432		
тэргүүн	125	145	166	145	155
эрхэлсэн	689	604	716	713	717
ахлах	2303	2303	2505	2641	2689
дэс	14205	14852	17233	17789	18087
туслах	3231	3231	1403	351	354
Төрийн тусгай	**45,453**	**45,899**	**47,158**	**47,657**	**47,689**
удирдах		4889	4558	4624	4609
гүйцэтгэх		30067	25786	33508	33533
туслах		10943	16814	9525	9547
Төрийн үйлчилгээ	**135,386**	**137,665**	**152,265**	**153,302**	**155,827**

удирдах	5291	6069	5977	5696	5941
гуйцэтгэх	96173	94871	104878	126368	126695
туслах	33922	36725	41410	21238	23191

Хүснэгт 9. Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэсэн тоон мэдээлэл

№	Он	Маргаан үүсгэж, маргаан хянан шалгах комисс байгуулсан	Бусад /Албан чигээр хариу өгсөн /	Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн	
				Шийдвэрийг хүчингүй болгосон	Шийдвэрийг хэвээр үлдээсэн
2	**2020 он**	22	-	14	8
3	**2021 он**	90	41	30	19
4	**2022 он**	63	30	23	10
5	**2023 он**	46	16	18	12
6	**2024 он**	21/1 хяналтад/	7	8	5
Нийт:		**242**	**94**	**93**	**54**

Хүснэгт 10.Төрийн албаны зөвлөл болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй буруутай албан тушаалтанд хүргүүлсэн мэдэгдлийн мэдээлэл

№	Он	Мэдэгдэл хүргүүлсэн тоо	Мэдэгдлийн агуулга	
			Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй	Шүүхийн шийдвэр биелүүлээгүй
1	2020	2	-	2
2	2021	4	4	-
3	2022	1	-	1
4	2023	-	-	-
5	2024	1	1	-
Нийт		**8**	**5**	**3**

Хүснэгт 11. Төрд учруулсан хохирлын болон нөхөн төлөлтийн мэдээлэл

№	Он	Шаардлага хүргүүлсэн тоо	Шаардлага хүргүүлсэн мөнгөн дүн /сая/	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо	Нэхэмжилсэн нийт үнийн дүн /сая/	Шүүхийн шийдвэр гарсан үнийн дүн /сая/	Нөхөн төлсөн үнийн дүн
1	2019 он	2	9.6	2	9.6	9.6	-
2	2020 он	1	6.6	1	6.6	2.2	6.7
3	2021 он	20	221.6	19	215.0	101.1	2
4	2022 он	27	303.0	7	107.0	145.7	39.5
5	2023 он	135	1.817.123.820	124	1.764.718.231	451.767.264	253.679.038
6	2024 он	105	1.701.626.059	55	1.506.441.430	-	403.727.438
Нийт:		**290**	**4.059.549.879**	**208**	**3.609.359.661**	**710.367.264**	**705.606.476**

Хүснэгт 12. Шүүхэд төлөөлж буй хэргийн тоо

№	Он	Иргэний хэрэг /нэхэмжлэгч/	Захиргааны хэрэг /хариуцагч/	Эрүүгийн хэрэг /Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч/
1	2019	2	5	0
2	2020	3	14	0
3	2021	6	17	0
4	2022	11	24	0
5	2023	43	21	1
6	2024	54	13	0
Нийт		**119**	**94**	**1**

Хүснэгт 13. Шүүх хуралдааны тоо

№	Он	Анхан шатны шүүх	Давж заалдах шатны шүүх	Дээд шүүх
1	2019	2	5	5
2	2020	3	14	10
3	2021	6	17	20
4	2022	140	41	1
5	2023	321	103	39
6	2024	95	25	-
Нийт		**567**	**205**	**75**